



**НАЛАЙХ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

┌ Дэд зөвлөл байгуулах тухай ─┐

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Налайх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газраас баталсан хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилтын хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэдэх дэд зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, ажиллах чиг үүргийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дэргэдэх дэд зөвлөлүүдийн үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн санхүүжилтийн зардлаас гаргахыг Нягтлан бодогч Б.Үүрийнтуяад зөвшөөрсүгэй.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга Г.Бадамд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.НЭРГҮЙ

190
Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 7 сарын
6 өдрийн 37-р тогтоолын 1-р хавсралт



1. ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГ, МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ДЭД ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга: Дүүргийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Цагдаагийн хэлтсийн эрүүгийн цагдаагийн тасгийн дарга

Гишүүд: ЗДТГ-ынТохижилт нийтийн үйлчилгээний хэлтсийн дарга

Цагдаагийн хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн дарга

ОБЕГ-ын харьяа УУАА-ийн дарга

Цэргийн штабын дарга

Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга

Цагдаагийн хэлтсийн Эрүүгийн цагдаагийн тасгийн эрүүгийн мөрдөгч

Цагдаагийн хэлтсийн урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн

2. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫГ ОСОЛ
ЭНДЭГДЭЛ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга: Нийгэм эдийн засгийн чиглэлийн төсөл хөтөлбөрийн удирдагч бөгөөд
Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга

Гишүүд: Цагдаагийн хэлтсийн Нийтийн хэв журмыг хамгаалах тасгийн дарга

Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга

Боловсролын хэлтсийн дарга

ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Цагдаагийн хэлтсийн Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан
сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн

Цагдаагийн хэлтсийн урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн

3. ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга: Хот төлөвлөлт, үйлдвэрлэл, ногоон хөгжлийн төсөл, хөтөлбөрийн удирдагч бөгөөд Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн тасгийн дарга

Гишүүд: ЗДТГ-ын Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга

Налайх хотын захирагчийн ажлын албаны ерөнхий менежер

ЗДТГ-ын Тохижилт, нийтийн үйлчилгээний хэлтсийн дарга

Цэргийн штабын дарга

Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн тасгийн ахлах байцаагч

Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн тасгийн замын цагдаагийн зохицуулагч

Цагдаагийн хэлтсийн урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн

4. АРХИДАН СОГТУУРАХ, ХАР ТАМХИ, МАНСУУРАЛТАЙ ТЭМЦЭХ ДЭД ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга: Дүүргийн Ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх

Нарийн бичгийн дарга: Цагдаагийн хэлтсийн Нийтийн хэв журмыг хамгаалах тасгийн дарга

Гишүүд: Цагдаагийн хэлтсийн дарга

ЗДТГ-ын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

ЗДТГ-ын Тохижилт, нийтийн үйлчилгээний хэлтсийн дарга

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга

Боловсролын хэлтсийн дарга

Налайх хотын захирагчийн ажлын албаны ерөнхий менежер

Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга

Онцгой байдлын хэлтсийн дарга

Цагдаагийн хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн ахлах байцаагч

Цагдаагийн хэлтсийн урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн

Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 7 сарын
6 өдрийн 31-р тогтоолын 2-р хавсралт



ДЭД ЗӨВЛӨЛҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ

1. ХУЛГАЙН ГЭМТ ХЭРЭГ, МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ДЭД ЗӨВЛӨЛ

а) Зохион байгуулалтын чиглэлээр:

-Хулгайн гэмт хэрэг, малын хулгайтай тэмцэх чиглэлээр ажлын төлөвлөгөө гаргаж ажиллах,

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, уулзалт, зөвлөгөөн, уралдаан, аян зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах,

-Хулгайн гэмт хэрэг болон мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажилд идэвх санаачилгатай ажилласан албан хаагч, малчдын бүлэг, иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг урамшуулах ажил зохион байгуулах,

-Мал сүргийг гэмт халдлагаас хамгаалах, "Малчин лавлах 109", "Тод сүрэг 1927" дугаарын утасны үйл ажиллагааг идэвхжүүлж олон нийтэд таниулах,

-Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хуулийг иргэд олон нийтэд сурталчлан таниулах,

-Зохион байгуулсан ажлын тайланг, дүүргийн ГХУСАЗСЗ-д улирал бүр танилцуулах.

б) "Гэр бүлсэг Налайх" хөтөлбөрийн хэрэгжилт:

-“Гэр бүлсэг Налайх” гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагааг нь дэмжин ажиллах,

-Хэв журмын урамшилт эргүүл, Сайн дурын эргүүлийг ажиллуулж, үр дүнг тооцох ,

-Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын дунд зарлагдсан “Камержуулалт 2” болзолт уралдааныг үр дүнтэй зохион байгуулах

2. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ, ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫГ ОСОЛ ЭНДЭГДЭЛ ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД ЗӨВЛӨЛ

а) Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхэд залуучуудыг осол эндэгдэл зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө гаргаж ажиллах,

-Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх “Түр хамгаалах байр” бий болгоход дэмжлэг үзүүлэн ажиллах,

-102, 107, 108 тусгай дугаарын үйлчилгээг иргэдэд сурталчлах,

б) Хүүхдийг осол эндэгдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

-Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хичээл заах, сургалтын цаг бий болгох,

-Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг таслан зогсоох ажлыг идэвхжүүлэх

-School police, Өсвөрийн сэргийлэгч бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх,

-Гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй хүүхэд залуучуудын судалгааг хороо, Цагдаагийн байгууллагатай хамтран гаргаж, зан үйл, сэтгэхүйг өөрчлөх, сургалт зохион байгуулах,

c) Зохион байгуулалтын чиглэлээр:

-Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор хороодын хамтарсан багийг чадваржуулах, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах,

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хороодын хамтарсан багийн дунд болзолт уралдаан зарлаж, дүгнэх,

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, уулзалт, зөвлөгөөн, уралдаан, аян зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах,

-Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Боловсролын тухай хууль болон бусад холбогдох хуулийг иргэд олон нийтэд сурталчлан таниулах,

-Зохион байгуулсан ажлын тайланг, дүүргийн ГХУСАЗСЗ-д улирал бүр танилцуулах.

3. ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧЛӨӨС

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД ЗӨВЛӨЛ

a) Хүүхэд хамгааллын чиглэлээр:

-СӨБ, ЕБС-ийн хүүхэд багачуудад замын хөдөлгөөний анхан шатны мэдлэг олгох, осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Замын хөдөлгөөний цагаан толгой" , "Ногоон гэрэл-цагаан шугам" тэмцээнүүдийг зохион байгуулах,

-ЕБС-ийн орчны бүс стандартыг хангах ажлыг эрчимжүүлэн, дэмжлэг үзүүлэх,

-Замын хөдөлгөөний аюулгүй байдал сэдвийн хүрээнд хүүхэд багачууд болон эцэг эхэд мэдлэг олгох сургалт хийх,

b) Зохион байгуулалтын чиглэлээр:

-Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө гаргаж ажиллах,

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, уулзалт, зөвлөгөөн, уралдаан, аян зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах,

-Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хуулийг иргэд олон нийтэд сурталчлан таниулах,

-Зохион байгуулсан ажлын тайланг, дүүргийн ГХУСАЗСЗ-д улирал бүр танилцуулах.

4. АРХИДАН СОГТУУРАХ, ХАР ТАМХИ, МАНСУУРАЛТАЙ ТЭМЦЭХ ДЭД ЗӨВЛӨЛ

а) Зохион байгуулалтын чиглэлээр:

-Архидан согтуурах, хар тамхи, мансууралтай тэмцэх чиглэлээр төлөвлөгөө гаргаж, ажиллах,

-Гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцлийн талаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх,

-Давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд хяналт тавих, нийгмийн халамж үйлчилгээнд хамруулан, ажлын байраар хангах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах,

-Сэтгэцэд нөлөөлөх эм, мансууруулах бодис хууль бусаар худалдаалах, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сурталчилгааны материал бэлтгэн, мэдээллийн хэрэгслэлээр түгээх,

-Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, хууль хяналтын байгууллагатай хамтран архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршгийн талаар олон нийтэд мэдлэг олгох сургалт зохион байгуулах,

-Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хуулийг сурталчлах,

б) Уул уурхай, аялал жуулчлалын бүс нутагт хяналт тавих чиглэлээр:

-Уул уурхайн эдэлбэр газар, аялал жуулчлалын бүс нутагт эргүүл хийж, хяналт тавих ажлыг эрчимжүүлэх,

-Үйлдвэр, уул уурхайн эдэлбэр газар, уурхайн нөхөрлөл, үйлдвэр, аялал жуулчлалын баазуудтай хамтран ажиллах, урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах,

-Өсвөрийн аврагч бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх,

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, уулзалт, зөвлөгөөн, уралдаан, аян зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах,

-Зохион байгуулсан ажлын тайланг, дүүргийн ГХУСАЗСЗ-д улирал бүр танилцуулах.